

Баядын аман аялгуу, зан үйлийн зарим онцлогоос

Н.Балжинням
/МУИС.МХСС/

Монгол хэлний Ойрад аялгууны доторх баяд аман аялгуу нь ойрад аялгууны бусад салбаруудтай, тухайлбал дөрвөд зэрэг аман аялгуутай нэлээд ойролцоо, энэ хоёр аман аялгууны үгэс өөр хоорондоо дуудлага болоод утгаараа бараг таарна. Харин монгол хэлний халх ойрад хоёр аялгуу өөр хоорондоо нэлээд ялгаатай, гэхдээ нарийн ажиглавал нэг юмны хоёр тал болох нь илт байдаг. Үүний учрыг Орос их эрдэмтэн В.Я.Владимирцов тэмдэглэхдээ: “Хамаг Монголын ярианы хэл нь өөр хоорондоо аль нэг талаараа ялгаа бүхий монгол олон аялгуу, монгол олон аман аялгуу юм” гэжээ.(Тал.-3). Гэхдээ эдгээр монгол олон аялгуутаны амьдралын хэв маягийн зарим нэг онцлогтой холбоотой үг хэллэг аль алинд нь бас бий. Энэ бол улс үндэстэний хэлэнд байдаг түгээмэл шинжийн нэг болно. Жишээлбэл, Баяд аман аялгуутаны ярьж, хэлдэг **жолом барих, жолом босгох, жовлоо босгох, дэглээ барих, хүвхэг барих...** зэрэг нийлэмж үгсийг Архангай, Өвөрхангай... зэрэг нүүдэл бага хийдэг, ойрхон нүүдэллэдэг аймгуудад ийм хэрэгцээ, шаардлага байхгүй учраас мэддэггүй байна. Алс нүүдлийн замд үдлэх, хоноглох үед хөнгөн маягаар гэрийн тооныг оруулахгүйгээр хэдэн хана босгоод, хэдэн унийн толгойг нийлүүлж боогоод орон болгож хүүхэд, настан зэргийг халуун, хүйтнээс хамгаалах нэг төрлийн гэрийг **жолом, дэглээ** гэх ба харин **хүвхэг** гэдэг нь хаваржааны бууцанд хана босгоод ариулах/хөнгөлөх/ хурга, ишгийг оруулж хоргоох байрын нэр юм. Энэ бол нэг ёсны хялбарчлан барьсан орон, байр юм. Энэ нь нэг ёсондоо амьдралын хэрэгцээ шаардлагаар нэрлэгдэхүүн нь бий болохын хамт юмын хэлбэр дүрс нь тухайн ястан бөлгийн оюун санаанд төсөөлөгдөн бууснаар нэр үүсдэг байна.

Харин баяд аялгуутан нь төв аялгуутаны байнга хэрэглэдэг идээ цагаа боловсруулах, ачаа бараа хадгалах зориулалт бүхий **бага гэр, илүү гэр** гэдгийг үгнийх нь утгыг ерөнхийд нь мэдэх боловч, чухам ямар зориулалт бүхий гэр болохыг тэд мэдэхгүй юм. Баруун монголд **илүү гэр** гэвэл **илүүдэл, хэрэгцээгүй** болсон гэдэг утгаар, **бага гэр** гэвэл **ядуухан айлын гурав юмуу дөрвөн ханатай гэр** байх нь хэмээн ойлгоно. Энэ мэтийн онцлог, ялгаатай зүйл нутаг нутагт нэлээд байна.

Баяд аялгуутан үг, яриандаа эерүүлэл их хэмжээгээр хэрэглэж, тухайн үгийн утгыг бүрэн ойлгож хэрэглэх нь бий. Жишээлбэл, *шорон* гэхийн оронд *хар гэр, их айл; чоно* гэдгийг *хангай, гарцусан, мөлхүү; жирэмсэн* гэхийг *хөл хүнд, бие давхар, бие шалтгаантай; залуу эхийн жирэмсэнийг тулгар; нас барахыг өөд болох, бурхан болох, бага хүүхдийн бүтэлгүй болохыг гүйж одох, оршуулах гэхийн оронд хөдөөлүүлэх, нутаглуулах; бие барагсадыг анх хөндөх зан үйлийг яс барих; мал хөнгөлөх, засах гэхийг ариулах; мал алах, нядлах гэж хэлэхийн оронд мал гаргах, малын ам барих; нялхасын шүд гарахыг цахиур ургах...* зэрэг зөөлөн үгээр хэлнэ. Зарим идээ, ундны нэрийг шууд хэлэх нь эв муутай гэж үзээд түүнийг *эерүү үгээр* хэлнэ. Хар цайг *бараан цай, бүгээн цай;* тэмээний махыг *машийн* эсвэл *өндөрхангайн мах,* адууны махыг

хулангийн мах, далны ясыг *хавтгай ясан*... гэж хэлнэ. Гэр бүлийн хүмүүсийн заримынх нь нэрийг өөр үгээр хэлнэ. Нөхрийн нэрийг эхнэр хүн шууд хэлэх нь заншилд таарахгүй хэмээн үзээд *манай хүмүн*, өвөөг *баавай*, бага охиныг *ноёхон*, бага хүүг *хэхэн*, нас биенд хүрч байгаа охиныг *сэвгэр*, хүүг *хөвүүн*... гэнэ.

Баядууд дээр үеэс олонд танигдсан өвөрмөц зан заншилтай, ёс уламжлалтай, овог төрлөө мэдэх, мэдүүлэх талаар өөрийн гэсэн аргатай улсууд гэж хэлж болно. Хүүхдийг ухаанд оронгуут л нутаг усны ойр хавийн овгийг бүгдийг нь хэлж өгнө. Аав, ээжийнх нь овгийг бусдаас илүү ойлгуулж, энэ овгийн хүмүүсийг ах дүү хэмээн үзэж явахыг зааж сургана. Ингэж эртнээс овог, төрлөө мэддэг болохоор үр хүүхдийнх нь гэр бүлийн асуудалд огтхон ч эргэлзээтэй зүйл гардаггүй. Зээ, нагацын холбоо маш нарийн юм шиг санагддаг. Нагац нар нь зээ нэрээ маш хүндлэнэ. Гэрт нь орох үед заавал гэрийн баганаар баримжаалан дээшээ суулгана. Зээ хүн нагацын баганаас доош суух ёсгүй хэмээнэ. Ёс алдвал нагац нарт муу болох цөвтэй гэнэ. Зээ хүн нагацын дэргэд далны ёс барих, дал мах идэх ёсгүй. Идэх болбол махыг нь авч өгнө. Ёс алдвал нагац нар хоосрох гэмтэй гэж сургамжлана.

Энэ дэлхийн хаана ч явсан овгийнхоо хүнийг таньж, халуун дотно уулзаж, илэн далангүй яриа өрнүүлж, ахмад нь сургааль захиасаа хэлж, дүүмэд нь анхааралтай сонсож хүлээж авна. Ахмад хүн заавал бэлэг өгнө, энэ нь элкийн хүмүүсийн хатуу тогтсон ёс болно. Залуучууд нь ахмад хүмүүст таних танихгүй нь хамаагүй маш хүндэтгэлтэй хандаж, тус дэмжлэг үзүүлнэ. Настай хүмүүсийг ирэхэд гэрийн эзэн, эсвэл тэдний их хүү нь тосон гарч, тусалж унаанаас нь буулгана. Унааг нь уяан дээр аваачиж уяна. Хонох болбол морийг нь аргамжиж, явах үед нь авч ирж, эмээллэж бэлэн болгоно. Зочныг гэрээс гарахад морийг нь уяанаас авч ирж түшиж мордуулна. Эс ингэвээс овог элкинээ мэддэггүй, ёс төргүйд тооцогдон ах дүү нэрээсээ хатуу зэмлэл хүлээнэ.

Баядын нүүдэл, суудал хийх зан үйл нь тун нарийн дараалалтай байдаг. Энд хэд хоногийн өмнөөс тэр айлын хүн бүр бэлдэнэ. Нүүдэл хийхийн өмнө буух бууцаа эргэж тодоруулна. Энэ нь айл хошоодын ахмад настай хэдэн хүн явж бууцаа эргэнэ. Энэ үеэр тэд хэн хэнийх хаана буухыг товлон. Энд бууриа булаацалдах явдал байдаггүй. Нүүдэл хийх нь эднийхний нэг ёсны баяр болдог юм. Ачаалахын өмнө ачаа бараагаа эмхлэж, тэмээ тэмээнийхээр тэнцүүлэн тавина. Нэг айл 6-7 тэмээ ачна. Ачаалах нь бас дараалалтай аж. Эхлээд номхон тэмээнд хөнгөн, заримдаг ачаагаа, сүүлд нь хүндийг нь, мөн хүүхэдтэй номхон тэмээг хамгийн сүүлд ачаална. Ачааг тэмээ тус бүрд тэнцүүхэн ачна. Ачаалж дуусаад гэрийн буурийг маш сайн цэвэрлэнэ. Буурь бууцаа хогтой орхих нь шившиг хэмээн үзнэ. Ачаалсан тэмээгээрээ гэрийн хуучин орыг гишгүүлдэггүй, учир нь нүүдэлд ачаа хэлтийнэ хэмээн болгоомжлоно. Ачаатай тэмээг дараалуулж хөтлөхдөө, эхлээд хүүхэдтэй тэмээг гарт гэх мэтээр хамгийн сүүлд тоонотой тэмээг чөрхлөнө. Ааштай залуу тэмээг номхон тэмээдийн дунд оруулна. *Нүүсэн айлыг бууриар нь шинж, буусан айлыг гэрээр нь шинж* гэдэг үгийг айл гэрийн нэр төрийг хадгалж явах хүү, охин хоёртоо эцэг эх нь хэзээ ч мартахын аргагүй болтол нь ойлгуулж мэдүүлнэ.

Айлын хүмүүс нүүдлээр өмсөх хувцасаа тусад нь болгож бэлдэнэ. Гэрийг ачаалаад дуусмагц ажлын хувцасыг замд өмсөх гоёлын хувцасаар сэлгэж өмсөнө. Мөн замд нүүдэл тосох айлын саванд хийж өгөх чихэр, амтганыг гарт ойр авч бэлдэнэ. Нүүдэл дэргэдүүр нь өнгөрөхөд суугаа айлын гэрийн эзэгтэй цай, идээ барьж тосож ирнэ. Нүүдэл түр зогсоод, ачаатай тэмээдийг шээж амрахын хооронд цай ууж, идээ идээд, тосож дайлсанд талархаж, чихэр амтганаар хариу бариад, цааш нь хөдлөнө.

Шинэ бууцанд буухаар очиход ойр хавийн айлуудын эрэгтэйчүүд давхилдан ирж, ачаа тайлалцаж, гэр барилцана. Эмэгтэйчүүд нь мөн идээ, цайтаа ирж, дайлаад гэрийн доторхыг эмхлэлцэнэ. Ингээд нүүж ирж буусан айл шинэ бууцны цайгаа чанаж, дээжийг нь нутаг усныхаа эзэн савдагт өргөөд, ирсэн хүмүүст өгч, өөрсдөө ууна. Энд цугласан хүмүүс цаг улирлын байдал, нутаг усныхаа газрын гарц, мал сүргийн тарга хүчийн талаар, хүн зоны амгалан, энхийн талаар эерэг сайхан яриа өрнүүлнэ.

Баядууд төрж өссөн нутаг орон, ундаалсан ус голдоо их хайртай, хаана ч явсан түүнийгээ сэтгэлдээ байнга тээж, цаг ямагт дурсан санаж явдаг улс юм. Намайг балчир хүүхэд байхад ээж минь өглөө бүр, бас шинэ цай чанах болгоны тоолонгоор дээжийг нь бариад хэдийнээ л баруунтаа хараад зогсчихсон –Ээ, хан Алтай минь, цэөг хайрхаан! хэмээн амандаа хэлээд л сацули гурвантаа өргөдөгсөн. –Хан Алтай тань хаана байна? хэмээн намайг асуухад, ээж минь хариу болгож, -Энэ баруун уулын цаана бий гэдэгсэн. Ээжийн минь идээнийхээ дээжийг байнга өргөдөг байсан тэр хан Алтай гэдэг нь Алтайн Нурууны зүүн өмнөөс Тэнгэр Уулын баруун суга хүрсэн өргөн уудам нутаг манай баядын өвөг дээдсийн ерөөлт нутаг байсан гэдгийг балчирхан хүү нь тэгэхэд яаж мэдэх билээ дээ. Түүхийн сурвалж бичгүүдэд XVII зууны эхээр баядууд Өвөр монголын зүүн урдуур суурьшиж, Алтайн уул, Эрчис мөрний эхээр нутагласан ойрадуудын дотор байсан баядууд XVIII зууны дундуур Алтайг давж монгол нутагт орж ирсэн төдийгүй, бүүр VI-VIII зуунд баядууд Буйр нуур хавиар нутагладаг, түүнээс хожуу үед Сэлэнгэ мөрний сав дагуу одоогийн Хиагт, Бүрэнхан уул хавиар нутагтай байсан талаар ч гардаг. Тэд нутгийнхаа уул, усанд үнэхээрийн хайртай улс. Одоо хэрнээ айл болгон байгаа газрынхаа өндөрхөн уул, толгод дээр овоо босгоод бараг л <<өмчлөөд>> авчихсан, идээ будааныхаа дээжийг байнга өргөж, ерөөлтэй сайхан үгээ хэлж л суудаг юм.

Баяд айл бүр ихэлтэй/морин хуур/, орсон гарсан хүн бүр түүнийг дуугаргаж, нэг буюу хэд хэдэн татлага татна. Өвлийн цагт хонио хотлуулчихаад, хоолоо идчихээд хот айлынхан ахмад настан айлдаа цуглаад нэг төрлийн цэнгээн хийнэ. Энэ бол ихлийн татлаганд биелэж бүжиглэх наадам юм. Найр ахаасаа, наадам дүүгээсээ гэдэг ёсоор биелгээ шахалт шаардлагагүйгээр дүү хүн эхлэнэ. Ингээд дараа дараагийн хүндээ хүндэтгэлтэйгээр дамжуулна. Харин ихлийн татлагыг сайн ихэлчид гүйцэтгэнэ. <<Жороо морины явдал>>, <<Ээвийн голын урсгал>>, <<Сацули>>, <<Елкэлдэг>>... зэрэг татлагууд орно. Ийм байдлаар өвлийн шөнийн нэгэхэн хэсгийг байгаа байгаа газартаа хөгжилтэй өнгөрөөнө. Биелгээ ерөнхий нэг дэгтэй байх боловч, сайн биечид баядын ажил хөдөлмөр, ёс заншил, зан үйлтэй... холбоотой дүрслэлт хөдөлгөөнөөр тухай бүр баяжуулан түүнийг ёстой л нэг болгож өгнө дөө. Зарим нэг чадвартан нь толгойн дээрээ аяга, аягатай ус тавиад биелэнэ. Байнга давтагдаж, дурсагдаж байдаг ихлийн нэгэн татлага буй нь <<Ээвийн голын урсгал>> юм. Түүнийгээ хүн болгон

сонсох дуртай. Сонсоход голын ус харгиатан, янз бүрийн дуу чимээ гарган урсах шиг ... болно. Энэ Ээвийн гол хаана байдгийг бас л сураглав. Олигтой мэдээ олж авсангүй явсаар тун саяхан Шинжааны Уйгурын нэг багшаас санаандгүй асуусан чинь тийм нэртэй том гол манай Шинжаанд байдаг юм гэж хэлсэн билээ. Ингээд бодоход юм гэдэг үнэхээр сонин гэж бодогдохоос аргагүй болдог юм. Ном зохиолоос одоогийн Уулын Алтай хэмээх хот эртхэндээ Ойрад туураа гэдэг нэртэй байснаа хожмоо нь Горно-Алтайск хэмээх нэрийг зүйх болсон, бас тэр нутагт Эрчис мөрний хөвөөнөө Аалайн хийд нэртэй Ойрадуудын гол шүтээн болох бурханы шашны хийд байгаад устгагдсан гэдгийг ч мэдэж авч билээ...

Баядуудын үр хүүхдэдээ шинэ гэр барих, хүүхдээ гэрлүүлэх ёст зан үйл нь бас л сонин, өвөрмөц юм. Хэнийх шинэ гэр барих, хэний хүүхэд гэрлэх, хэний охин мордох... зэрэг зан үйлийг овог-элкинээрээ мэдэж байх ёстой. Учир нь, энэ зан үйлд тэр овог-элкинийхэн толгой дараалан оролцож, заавал өөр өөрсдийн хувь нэмрийг оруулдаг ёстой байна. Зан үйлийн ёслол хийх айлд ах дүү нэр нь өөрсдийн санаачлагаар оруулах хувь нэмрээ хэлж тохиролцсоноор ах дүү нарын хийх ажил тодорхой болно. Ингээд ёст өдрийн өглөөгүүр эсгий ганзгалах нь эсгийтэйгээ, гэрийн бүс, оосор бүч авч ирэх нь түүнийгээ аван зүг зүгээс ирцгээж, шинэ гэрийг төвөггүй барина. Тэнд дутуу юм гэж нэг ч гардаггүй нь их сонин. Дараа ээлжинд мөн л нэгнийх нь энэ зан үйл ийм л байдлаар болно. Энэ талаар мөхөсдүүхэн тэмдэглэгч баяд ястан, монголмууд овогт миний гэрийн эсгий бүрээс, оосор, бүч... зэргийг 1973 оны дэлгэр зуны тэр нэг ерөөлт сайн өдөр миний ах дүү нэр, нагац нар нар минь дээрхийн адилаар бэлэн болгоод, таван ханатай гэрийн яс модонд таарна, санаа зовох юмгүй шүү гэж хэлээд, намайг Архангай аймаг руу явуулж билээ. Хэлсэн ёсоор нь би тэдгээрийг халх аймагт авч ирээд намар нь шинэ гэр барихад ганц ч оосор бүч дутагдалгүй таарсанд өөр аймаг, хошууныхан миний овог-элкинийхэнд билэгтэй сайхан үг хэлж, ажил ч хичээнгүйг нь бахархан ярьж байсныг одоо хэр санаанд тодхон байж, нэг амь болон яваа ахан дүү нэр, овог-элкинийхэндээ сайны ерөөл байнга бодож, энэ ёс заншил үеийн үед бие биенээсээ бие биендээ дамжин уламжлаасай хэмээн бодож явдаг юм.

Баяд ястаны хэл яриаг ажиглахад нэлээд уянгалаг, хөг сайтай, аялгуулаг юм шиг санагддаг. Баяд аялгуугаар –Юун акаад юм хэлдийм ч! Яасан сонин юм хэлнэ вэ! Түүнэ хэсн юмиг халиагаад би наам аланг боллаав. Түүний хийсэн зүйлийг хараад би ихэд гайхав. Боран орж аашнаа л, гарч гэрэн иргээр ариг авцхаатана. Бороо орох нь байна, гарч гэрийн хаяагаар шуудуу татацгаа. Гуярыг агуун нухухла нь хоола акаад болдийм. Гурилыг хатуу зуурвал, хоол сайхан болдог. Хазаран ууд, төөлгэ хуяриг сайн кэк кэрэгтэй. Эс тэгжим гилэ мориан алдниш. Хазаарын амгай, зуузай хоёрыг сайн хийх хэрэгтэй. Эс тэгвээс морио алдаж болно. Бөкүүнд шуучулад бараг үккэ шахлаав. Шумуулд хазуулаад бараг үхэх шахав. Иймэрхүү яриаг орчинд нь сонсвол үнэнхүү аялгуулаг, түүнийг ахин дахин сонсмоор санагдана.

Баяд ястаны эрхэмлэдэг хорио, цээрээс дурдвал; -Гал голомт руугаа хар ус хийхгүй байх; Гал голомтоо харааж зүхэхгүй байх; Гал голомтондоо баас, шээс, хог новш зэрэг муу муухай зүйлийг оруулахгүй байх; Гал голомтын ойр орчинд нус нийх, цэрээ хаяхгүй байх; Хар ус самрахгүй байх; Зогсоогоор унд, хоол идэж уухгүй байх; Гар тээрмийн чулууг өнхөрүүлэх, чирэх хийгээд түүгээр хүүхэд тоглохыг хориглоно;

Гэрийн багана түшиж зогсохыг хориглоно; Багачуудад чүдэнз, гал бариулахгүй байх; Солонгын зүг гар, хуруугаар заахгүй байх; Бурхан шүтээний зүг хөлөө харуулахгүй байх; Айлд ирсэн хэн боловч ташуураа барьж гэрт орохгүй байх; Эцэг эх болон ахмад хүмүүсийн дэргэд багачууд архи уух, тамхи татахгүй байх; Малын хэшиг өдөр/хонь, морь, үхэр/ гэрээс юм гаргах, хүнд гадагш юм өгөхгүй байх; Арван хоёр жилийг ахладаг ам цагаан хулгана өдөр гэрээс юм гаргах, бусдад эд зүйл, мал агуурс өгөхийг хориглоно; Бэр хүн хадам аав, ээжийгээ нэрээр нь дуудахгүй байх... зэрэг болно. Ингэж тэмдэглэхийн учир гэвэл, монголчууд бид бие биенийхээ хэл яриа, ёс заншилын өвөрмөц зүйлийг тэр болгон мэдэхгүйгээс болоод ахмад хүнтэй уулзаж ярих, аливаа ёст үйл ажиллагаанд оролцох үедээ ёс алдах нь монгол монголдоо шившигтэй төдийгүй, гадаадын хүний нүдний өмнө шившиг болох нь байдаг учир далайд дусал болгож буй хэрэг юм.

Ном зүй

1. Antoine Mostaert, Dictionnaire Ordos, New-York. London, 1968.
2. Владимирцов Б.Я., Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Ленинград, 1929
3. Тодаева Б.Х., Язык монголов Внутренней Монголии, Москва, 1981
4. Oyirad nutug-un ayalgun-u üges-ün quriyanggui, 1994, Öbür monggul-un yeke surgaguli-yin keblel-ün qoriy-a
5. Калмыцко-русский словарь, Москва, 1977
6. Советский энциклопедический словарь, Москва, 1986
7. Цолоо Ж., БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг, II дэвтэр, Улаанбаатар, 1988

Summary

This article discusses the features of subdialect Bayat and customs, in Mongolia. This author has elaborated on the differences between the above subdialect and other dialects of the central and eastern Mongolia. The article sufficiently illustrates several examples of the subdialect and ritual rite of these nationalities. On author opinion, the subdialect Bayat have many words from ancient Mongolian written language, which is extinct nowadays. The author is concerned that domestic and foreign dialektologists not pay sufficient attention to the study and publication of materials on the local dialect.

Finally, the author emphasizes the significance of mutual influence of local dialects that would benefit the development and modernization of the contemporary Mongolian language in general. The author has no doubts that this article presents crucial issues for ethnologists, linguist and other scholars.